



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/106

Чингис хот

Урьдчилан сэргийлэх арга хэмжээг
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Засгийн газрын 2020 оны 62, 64 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 02 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 07 дугаар хурлын тэмдэглэл, аймгийн Онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 08 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан орон нутагт зорчигч тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 08:00 цагаас 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд хязгаарласугай.

2. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд архи, согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 03-ны хүртэлх хугацаанд зогсоосугай.

3. Хэсэгчилсэн байдлаар өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж байгаа гамшгаас хамгаалах мэргэжлийн албад болон байгууллага /Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Авто тээврийн үндэсний төв, Эрүүл мэндийн газар, аймаг, сумдын Онцгой комисс, Засаг даргын Тамгын газар/-ын үйл ажиллагааг хэвийн явуулж төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн албан тушаалтнуудыг 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийг хүртэлх хугацаанд ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллуулахыг байгууллагын дарга, захирал нарт зөвшөөрсүгэй.

4. Баар, караоке, спорт заал, бялдаржуулах төв, шашны байгууллагуудын үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд зогсоосугай.

5. Коронавируст /COVID-19/ халдварын нөхцөл байдалтай холбогдуулан нутаг, дэвсгэрийн хэмжээнд бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх, Коронавируст халдвар гарсан улс оронд оршин сууж байсан, дамжин өнгөрсөн, халдвартай хүнтэй болон сэжиг бүхий хүнтэй хавьтал болсон /хамт байсан, нэг унаанд суусан зэрэг/ өгүүлэмжтэй хүмүүсийг

20200229

тусгаарлах байранд 14 хоног өөрсдийнх нь зардлаар тусгаарлаж, шинжилгээний хариу гартал ажиглалт хийж шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авч ажиллахыг Эрүүл мэндийн газар, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай

6. Тусгаарлах болон ажиглалт хийх байрыг бэлтгэхтэй холбогдуулан гарах зардлыг орон нутгийн нөөц боломжийг дайчлан, ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч Г.Хэрлэнчулуун, Шуурхай штабын дарга, дэд хурандаа Н.Чанцал нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА